# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 12 өдөр Дугаар А/594 Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 242 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 3,499,000.00 (гурван сая дөрвөн зуун ерэн есөн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 242 дугаар цэцэрлэг (Я.Мөнхтуяа)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 4 нэр төрлийн 3,499,000.00 (гурван сая дөрвөн зуун ерэн есөн мянга) төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг Баянгол дүүргийн 242 дугаар цэцэрлэг (Я.Мөнхтуяа)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 12 -ны
өдрийн А/594 дугаар тушаалын хавсралт

# Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 242 дугаар цэцэрлэг

| № | Эд хөрөнгийн нэр | Ашиг-ласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэг-дэл өртөг | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | Байгуул-лагын үнийн санал | ҮХХХХ Комиссын хурлын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зөөврийн компьютер 2020 | 5 | ш | 2 | 1,749,500.00 | 3,499,000.00 | 3,499,000.00 | - | Ажлын шаардлага хангахгүй | актлах | 0 | татах |
| Машин, тоног төхөөрөмжийн дүн | | | | 2 | | 3,499,000.00 | 3,499,000.00 | - | - | - | - | - |
| Нийт данснаас хасах хөрөнгийн дүн | | | | | | 3,499,000.00 | | | | | | |
| Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгө | | | | | | | | | | | | |
| Татах хөрөнгө | | | | 2 | | 3,499,000.00 | | | | | | |
| Устгах хөрөнгө | | | | | | | | | | | | |
| Худалдсанаас олох орлого | | | | | | | | | | | | |
| НӨХГ-т төвлөрүүлэх 30% | | | | | | | | | | | | |